


БАТЛАВ:  
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.НЯМСҮРЭН

Улаанбаатар хот



**“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ БА ТЭГШ ХҮРТЭЭМЖ- 2022” ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ**

2022.10.21

Улаанбаатар хот

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ийн конвенцын 8 дугаар зүйлийг тус тус үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн нэг гишүүн байж, бусдын адил сурч, боловсорч, хөдөлмөр эрхлэх, эрүүл амьдрах бүрэн эрхтэйг нийгэмд ойлгуулж, тэдний нийгэмд эзлэх байр суурийг нийгмийн бүхий л давхаргад бий болгох, хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдэд хүрч байгаа бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг тэгш хүртээмжтэй, судалгаа, шинжилгээнд тулгуурлан үзүүлэх шаардлагатай байна.

Энэхүү хурал нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бүхий л салбарт судалгаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулийн оюутан, эрдэмтэн, багш, судлаач, шинжээчдийн оролцоо, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх, туршлага солилцох, судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээл судлал салбар шинжлэх ухааныг хөгжүүлэх зорилготой юм.

**ХОЁР. СЭДЭВ**

Хөгжлийн бэрхшээл судлалд салбар хоорондын уялдаа холбоо сайжруулах чиглэлээр доорх сэдвээр нээлттэй оролцоно. Үнд:

- Эрүүл мэнд
- Боловсрол
- Хөдөлмөр эрхлэлт
- Нийгмийн хамгаалал
- Дэд бүтэц
- Хууль, эрх зүй

**ГУРАВ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

- 3.1 “Хөгжлийн бэрхшээл ба тэгш хүртээмж- 2022” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг үндэсний хэмжээнд нээлттэй зохион байгуулна.
- 3.2 4 шагналт байр шалгаруулна.

**ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 4.1 Хэзээ: 2022 оны 11 дүгээр сарын 30 өдөр
- 4.2 Хамрах хүрээ: Хөгжлийн бэрхшээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, багш, судлаач, шинжээчид, их дээд сургуулийн оюутан /бакалавр, магистр, докторант/ нар оролцоно.
- 4.3 Ерөнхий зохион байгуулагч: Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар

4.4 Хаана: Танхим болон цахимаар тухайн үед байршлыг зааж зохион байгуулна.

#### ТАВ. БҮРТГЭЛ

5.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авах хугацаа: 2022.10.24-11.18-ны 09:00 цаг хүртэл

#### ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА

6.1 Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах шаардлагыг хангасан байвал зохино:

- Хэмжээ

Өгүүлэл нь МОНГОЛ хэлээр, Microsoft Word программ дээр бичигдсэн байх ба цаасны хэмжээ А4, дээд захаас 25 мм, доод захаас 25 мм, баруун захаас 20 мм, зүүн захаас 30 мм, Arial фонд, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зайд 1.5 байна. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй байна. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино. Нийт ЭШӨ үгийн тоо 4500 үгнээс хэтрэхгүй байна.

- Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) нь дараах бүтэцтэй байна.

- 1) Өгүүллийн нэр – Arial фондоор, 14pt, Bold, ТОМ ҮСГЭЭР, мөр голлоно.
- 2) Зохиогчийн нэр, хаяг - Arial фондоор, 12pt, мөр голлоно. зохиогчдын нэрийн баруун дээд өнцөгт 1,2 гэх мэтээр тэмдэглэн нэrsийн доор зохиогчийн албан газрын нэр байна.
- 3) Хураангуй - Arial фондоор 15 мөр 250 үгэнд багтаан, мөрний эхнээс эхлэх ба мөр хоорондын зайд 1sp бичнэ.
- 4) Түлхүүр үг – Өгүүллийн санааг гаргахуйц ганц тоогоор 3-5 түлхүүр үг хэрэглэж бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 5) Удиртгал болон оршил хэсэг- Энэхүү хэсэгт судалгааны үндэслэл хэрэгцээ, шаардлага, онол, арга зүйн үндэслэл, судлагдсан байдал, тоо баримт, гол онцлогуудыг бичнэ. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 6) Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол, Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 7) Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн: – /Судалгааны субъект, судлах зүйл, хугацаа, зохион байгуулалт, түүврийн хэмжээ, хэрэглэсэн арга зүй, аргачлал, статистик боловсруулалт гэх мэт/ Arial фондоор, 12pt, зүүн, талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 8) Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй – /Судалгаанаас гарсан үр дүнг бусад судлаачдынхтай харьцуулан үнэлж дүгнэж тодорхой бичих/ Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 9) Хүснэгт болон зураг нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт болон зургийн гарчиг нь Arial фондоор, 12pt, italic хэлбэрээр мөр голлон (хүснэгт 1..., Зураг 1... гэх мэт) бичигдэнэ. Бүх математик бичлэгүүд MS Equitition, MathType, La Tex программаар бичигдэх бөгөөд ердийн математик бичиглэл 12 pt өндөртэй байна. Томъёо нь дээд, доод талаасаа 12 pt зйтай байх ба мөр голлон бичигдэнэ. Томъёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага (1) хаалтанд бичнэ.

- 10) Зургийг JPG форматаар, диаграммыг Microsoft Excel програм дээр үйлдэнэ. Фото зураг, зураг, хүснэгт нь зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг нь 300-400 dpi-аас багагүй нягтралшилтайгаар зургийн \*.JPEG өргөтгөлтэйгээр буулгагдаж текстэн дотор мөр голлон байрласан байна. Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн үсэгний өндөртэй тэнцүү байна.
- 11) Дүгнэлт – /Үр дүнд тулгуурласан товч тодорхой байх/ Arial фондоор, 12pt, мөрүүд нь баруун зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
- 12) Санал, зөвлөмж- /Үр дүнд тулгуурласан товч тодорхой санал байвал бичиж болно/
- 13) Талархал - /Үг судалгааг явуулахад тусалсан хамт олон, хүмүүсээ бичих/
- 14) Ашигласан хэвлэл- Arial фондоор, 10pt, зүүн талдаа зэрэгцэх. Өгүүллийн төгсгөлд ишлэл татсан ном, сэтгүүл, зохиолын нэрс, вэб хаягийг бичих бөгөөд өгүүлэлд иш татсан дарааллаар дугаарлана. Ишлэлийг АРА загварын дагуу бичих бөгөөд ном зүйн зүүлтийг [...] хаалтанд хийнэ. Жишээ нь: [1]. Нэг газар өмнөх ишлэл татах бол [1, 2, ...] гэж дугаарлана.

#### **Ашигласан материал:**

- [1]. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банк. (2020). Коронавирусын нөлөөллийг тодорхойлох өрхөд суурилсан судалгаа: Эхний шатны үр дүн. Монгол Улс, Улаанбаатар хот.
  - [2]. OECD (2020). *How's Life? 2020: Measuring Well-being-Highlights*. Paris. Retrieved from <https://www.oecd.org/sdd/How-is-Life-2020-Highlights.pdf>
  - [3]. Bronfenbrenner, U., & Evans, G.W. (2000). Developmental science in the 21st century: Emerging questions, theoretical models, research designs and empirical findings. *Social development*, 9(1), 115-125.
- Жич: Эмхтгэлд орох материал нь шаардлага хангагүй өгүүллийг буцаах, зохих хэмжээнд засварлаж болох талтай. Өгүүллийг шаардлагын дагуу бичиж, агуулга, найруулга, үг үсгийн алдаанд анхаарч хянуур нямбай хандахыг хүсье!

#### **ДОЛОО. ШАЛГАРУУЛАЛТ**

- 7.1 Энэхүү эрдэм шинжилгээний хурал нь 2 үе шатаар явагдана.
- 7.2 Нэгдүгээр үе шатанд ирсэн бүх илтгэлүүдээс 8 илтгэлийг сонгон шалгаруулж, эрдэм шинжилгээний хурал дээр хэлэлцүүлнэ. /Сонгон шалгаруулах хугацаа 2022.11.18-2022.11.23/
- 7.3 Хоёр дугаар үе шат хэлэлцүүлсэн 8 илтгэлээс шилдэг 4 судалгааны ажлыг шалгаруулж шагналт байр эзлүүлнэ.
- 7.4 Шагналт 4 байрыг шалгаруулахад дараах үзүүлэлтүүдийг тавина:
  - Шинэлэг санаа дэвшүүлсэн байдал
  - Практик ач холбогдол
  - Асуудал дэвшүүлж, зорилгодоо хүрсэн байдал
  - Судалгааны арга аргачлал
  - Илтгэх ур чадвар

#### **НАЙМ. БҮТЭЭЛ ХЭВЛҮҮЛЭХ**

- 8.1. ЭШӨ-ийн бүтцийн дагуу шаардлага хангасан илтгэлийг илтгэлийн хураангуйд оруулна.
- 8.2. Илтгэлийн хураангуйг цахим болон товхимолоор хэвлүүлж олны хүртээл болгоно.